

“Дархан Гурил Тэжээл” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын протокол.

2015 оны 4-р сарын 20-ны өдөр

Дархан-Уул аймаг, Дархан сум

“Дархан Гурил Тэжээл” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал 2015 оны 4-р сарын 20-ны өдрийн 12.30 цагт Дархан-Уул аймаг, Дархан сумын 1-р баг, “Дархан гурил тэжээл” ХК-ийн гүйцэтгэх захирлын өрөөнд эхлэв. Ээлжит хурлыг ТУЗ-ын дарга Э. Содгэрэлийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Э.Одбаяр удирдав.

Э. Одбаяр: хурлын тооллогын комисст Р. Болдбаатар, П. Эркебулан, С. Пүрэвжав нар томилогдсон, П. Эркебулан шүүх хуралтай учир хуралд оролцох боломжгүйгээ хэлсэн. Тооллогын комиссыг хурлын ирцийн талаар мэдээлэл хийхийг хүсэв.

Р. Болдбаатар: Хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийн тоог тооллогын комисс бүртгэсэн тухай танилцуулав.

Нийт 550527 ширхэг хувьцаа эзэмшигчид буюу нийт хувьцааны 89.6% хувийн эзэмшигчид ирсэн, Компанийн тухай хууль болон “Дархан гурил тэжээл” ХК-ийн дүрмийн 5.5.21-д зааснаар ирц хүчин төгөлдөр тул хурлын хуралдуулахаар шийдвэрдэв.

Хурлын даргад С. Намсрайжав Э. Одбаярыг санал болгож, хуралд оролцогчдын 100%-ийн саналаар батлав.

Э. Одбаяр: Ээлжит хурлын хэлэлцэх асуудлын жагсаалтыг танилцуулав:

- 1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай 15 мин
- 2. Компанийн хэлбэрийг өөрчлөх 15 мин
- 3. Бусад цаг тогтоохгүй

Оролцогчдын 100% саналаар хэлэлцэх асуудлыг батлав.

Э. Одбаяр: Хурлын дэгийг уншиж танилцуулав, дэгийг хавсаргав.

Хурлын дэгийг 100% санал нэгтгэйгээр батлав.

Э.Одбаяр: Хурлаар хэлэлцэх асуудалдаа оръё. Эхний асуудал, ““Дархан гурил тэжээл” ХК-ийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи дүгнэлтийг хэлэлцэж, батлах” тухай асуудал байгаа. Гүйцэтгэх захирал С. Намсрайжав.

Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн талаархи дүгнэлтийг гүйцэтгэх захирал С. Намсрайжав товч танилцуулав. Танилцуулгыг хавсаргав.

Э.Одбаяр: Танилцуулгатай холбоотой асуулт байна уу?

Д. Балдан-Очир: 2014 оны санхүүжилтын эх үүсвэрийн талаар тодруулах.

С. Намсрайжав: Компанийн нэр дээр том зээл бүртгэлтэй байгаа тул бусад банкнаас зээл авах ямар ч боломжгүйгээс ХХААЯ-ны зарласан тендерт орж ялсан. Тендер эцэслэн дуусаагүй байгаа тул төсвөөс санхүүжсэн эх үүсвэрийг байгууллага хоорондын тооцоогоор бүртгэсэн байгаа. Эргэлтийн хөрөнгийн дутууг ББСБ-аас гүйцэтгэх захирлын хувийн эд хөрөнгийг барьцаалан удаа дараа зээлсэн. Зээлээр авсан мөнгөн хөрөнгө дүнгээрээ холбогдох дансаар дамжиж, санхүүгийн бүртгэлд тусгагдсан.

Д. Балдан-Очир: 2014 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийлгэсэн үү?

С. Намсрайжав: "Ай Жэй Эй Эйч-Аудит" ХХК-д хандан гэрээ байгуулан байгууллагын 2014 оны санхүүгийн тайланд дүгнэлт гаргуулсан. Компанийн санхүүгийн байдалд бүрэн судалгаа хийсэн, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эхлэхэд санхүүгийн тайланд байгаа найдваргүй авлагыг цэгцлэх, хөрөнгийн үнэлгээг шинэчлэх гэх мэт зайлшгүй хийх өөрчлөлтийн талаар тайлбарласан. Техник, технологийн шинэчлэл хийгдсэнээр шинэ гурилын үйлдвэрлэл эхлэх цаг үед мэргэжлийн зөвлөгөө өгч Төлөөлөн удирдах зөвлөлтэй хамтран ажиллаж, хөрөнгийн үнэлгээ зэрэг зайлшгүй шаардлагатай санхүү, зардлын бүртгэлийг шинэчлэн боловсронгуй болгохоор тохирсон.

З. Арсланбаатар: Асуулт алга аа.

Э.Одбаяр: Өөр хэнд ямар асуулт байна вэ?

Д. Балдан-Очир: Голомт банкны зээлийг төлөх тал дээр анхаарах, юуны түрүүнд гэрээний нөхцөлийн зөрчлийг арилгах тал дээр ажиллах хэрэгтэй.

Э.Одбаяр: Нэгдүгээр асуудлаа хэлэлцэж дууслаа, өөр асуулт алга. Хэлэлцсэн асуудлыг дүгнэж хурлын тогтоолын төсөл танилцууллаа.

Хуралд оролцогсод 100%-ийн саналаар батлав.

Э.Одбаяр: хэлэлцэж буй асуудлуудаар гарах шийдвэрийг дор бүр нь танилцуулаад санал хураагаад явъя, төгсгөлд нь санал авах хуудсаар давхар баталгаажуулна гэлээ.

Хоёр дахь асуудал, "Дархан гурил тэжээл" ХК-ийн хэлбэрийг өөрчлөн хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөх тухай асуудлыг авч хэлэлцье.

Э.Одбаяр: Энэ тухай том хувьцаа эзэмшигчид нэг биш удаа санал солилцоод компанийнхаа хэлбэрийг солих нь зүйтэй гэж ярилцсан.

Ш.Энхтөр: Энэ их материал бүрдүүлдэг нөсөр хөдөлмөр бүхий ажил байна, Санхүүгийн зохицуулах хорооны мөрддөг журмын дагуу материал бүрдүүлж өгөх шаардлагатай. Энэ удаагийн хурлаар ерөнхий шийдвэрээ гаргаад ажлын хэсэг байгуулаад хугацаатай үүрэг өгч шийдүүлбэл ямар вэ?

Э.Одбаяр: Цаг хугацаа, санхүү төлбөрийн хувьд багтаагүй тул ажлын хэсэг байгуулаад шуурхай ажиллаж бичиг баримтаа бүрдүүлэх нь зүйтэй байна. Компанийн хэлбэрийг өөрчлөх талаар санал хураалт явуулъя.

Компанийг өөрчлөн байгуулах тухай тогтоолын төслийг Э.Одбаяр танилцуулав.

Хуралд оролцогсдын 100%-ийн саналаар зөвшөөрлөө, ажлын хэсгийнхэнд шуурхай ажиллахыг сануулж амжилт хүсье.

Э.Одбаяр: Өөр санал асуулт байна уу,

З. Арсланбаатар: Компанийн засаглалын тухай сургалтанд хамрагдах шаардлагатай байгаа

Ш. Энхтөр: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд албан ёсоор Компанийн засаглалын асуудлаар сургалтанд сууж, сертификаттай болох үүрэгтэй. Хуулинд заасан байгаа, иймд энэ сургалтанд сууж гэрчилгээтэй болох ажлыг зохион байгуулж, шийдвэрлэхийг гүйцэтгэх удирдлагад үүрэг болгох нь зүйтэй.

Э.Одбаяр: Өөр санал асуулт байна уу,

С. Намсрайжав: Компанийн дүрмэнд оруулах жижиг өөрчлөлт байгаа, та бүхэнд дүрмийн төслийг хэвлэж тараасан. Гол нь Туркийн мэргэжилтнүүдтэй хамтарсан гурилын үйлдвэрийн засвар үйлчилгээ эрхлэх талаар компанийн дүрмэнд тусгах шаардлага гарсан. Улсын бүртгэлийн албанаас Хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталгаажуулахыг шаардсан.

Э.Одбаяр: Компанийн дүрмийн төслийг батлах талаар санал хураая, Хуралд оролцогсдын 100%-ийн саналаар зөвшөөрлөө.

Э.Одбаяр: Дархан гурил тэжээл ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдаж төлөвлөсөн асуудлуудаа хэлэлцэж холбогдох шийдвэрүүдийг гаргалаа. Хурлын материалаа Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн бирж, Улсын бүртгэлийн албанд хүргэж, бүртгүүлэх ажлыг ТУЗ, гүйцэтгэх удирдлага хүлээж байна. Хуралд оролцсон та бүхэнд талархал илэрхийлж, ажлын амжилт хүсье.

Хурал 2015 оны 4-р сарын 20-ны 14.00 цагт өндөрлөв.

Хурлын дарга

Хурлын тэмдэглэл хөтөлсөн



Э.Одбаяр:

Д.Мөнхцэцэг